

**МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ**

1996 оны 11 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нөхөрлөл,компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйл, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтийг үндэслэн Монгол улсын Үнэт Цаасны хорооноос **ТОГТООХ** НЬ:

1. “ Хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчилсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гишүүдийн бүртгэл хөтлөх тухай” журмыг хавсралтад дурдсанаар баталсугай.
2. Энэ журмыг мөрдөж ажиллахыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн удирдлагад даалгасугай.
3. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д, Монголын хөрөнгийн бирж /О.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

**ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАМЖУУЛАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХИЙН БИЧГЭЭР
ХУВЬЧИЛСАН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГИШҮҮДИЙН
БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү журам нь хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчилсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн /ХХК гэх/ гэх гишүүдийн эзэмшиж байгаа ногдол хувианы бусдад шилжүүлсэнийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж, хянах үйл ажиллагааг зохицуулна.

2. Компанийн гишүүдийн бүртгэлийн дэвтрийг тус компанийн удирдлага болон компанитай гэрээ байгуулсан үнэт цаасны аль нэг компанид хөтөлнө.

3. Компанийн гишүүдийн бүртгэл хөтлөх үнэт цаасны компанийг сонгох, гэрээ байгуулах асуудлыг гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

4. Компанийн гишүүдийн бүртгэл хөтлөж буй этгээдүүд нишүүдийн хурал зарласан өдрөөс эхлэн ажлын 4 хоногийн дотор хуралд хуралд оролцох эрх бүхий гишүүдийн нэрсийн жагсаалтыг хурал зохион байгуулах комисст гаргаж хүргүүлнэ.

5. ХОЭБ-ээр хувьчилсан ХХК-ийн ногдол хувиар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг Иргэний хууль болон Нөхөрлөл, компанийн тухай хуулийн холбогдох заалтийн дагуу бусдад шилжүүлж хуулийн хүчин төгөлдөр баримт бүрдүүлсэн этгээдийг тухайн компанийн гишүүдийн бүртгэлд бүртгэнэ.

/Үнэт цаасны хорооны 1998 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 115 дугаар тогтоолоор нэмсэн/

~~— 5. Тус компанийн гаргасан ногдол хувийн 20 буюу түүнээс дээш хувийг бусдад шилжүүлж зөвшөөрлийг гишүүдийн хурлын шийдвэрээр олгоно. Үүнээс доош ногдол хувийг бусдад шилжүүлж зөвшөөрлийг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр олгоно.~~

~~— 6. Гишүүдийн дараагийн хурал хүртэл хугацаанд ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлсэн ногдол хувийн хэмжээ нийт ногдол хувийн 20 хувиас хэтрэхгүй байна.~~

/Үнэт цаасны хорооны 1998 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 115 дугаар тогтоолоор хүчингүй/

Хоёр. НОГДОЛ ХУВЬ ШИЛЖСЭНИЙГ БҮРТГЭХ

6. Компанийн ногдол хувийг шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлж авсан ногдол хувийг тус компанийн гишүүдийн бүртгэлийн дэвтэрт ажлын 7 хоногийн дотор бүртгүүлнэ.

7. Шилжүүлж авсан ногдол хувийг бүртгүүлэхдээ тус ногдол хувийг тухайн этгээдэд шилжүүлэхийг зөвшөөрсөн бусад гишүүний зөвшөөрөл, шилжүүлсэн актын нэг хувь, шинэчилсэн гэрээ, төлбөр хийсэн болон бүртгэлийн шимтгэл төлсөн баримтын хуулбарыг бүрдүүлнэ.

8. Компанийн ногдол хувийг бусдад шилжүүлсэн актыг маягт № БЗ-1- ээр үйлдэнэ.

МАЯГТ № В3-1

НОГДОЛ ХУВИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН АКТ

199... оныдүгээр сарын-ны өдөраймаг, хот

199... оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн
.....ХХК-мйн ширхэг
ногдол хувийг эзэмшиж байгаа овогтой
.....өөрийн эзэмшиж буй ногдол хувиас
.....ширхэгийг овогтой
.....-нд 199.. оныдүгээр сарын-ний өдрөөр
тасалбар болгон шилжүүлэв.

НОГДОЛ ХУВИЙГ

Шилжүүлж өгсөн этгээд
.....
/гарын үсэг/
Паспортын сери

Шилжүүлж авсан этгээд
.....
/гарын үсэг/
Паспортын сери

Дугаар
Регистрийн дугаар
.....
.....

Дугаар
Регистрийн дугаар
.....
.....

199.. оныдүгээр сарын-ны өдөр

199.. оныдүгээр сарын-ны өдөр

Нотариатын болон засаг даргын батламж:

.....
.....
.....

199... оны дүгээр сарын-ны өдөр